



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/58

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.5-д “Хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудыг чадавхижуулах, материаллаг байдлыг нь сайжруулахад дэмжлэг үзүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд “Олон нийтийн цагдаагийн ажилтныг чадавхижуулах сургалт, зөвлөгөөн”-ий зардалд зориулж 1.902.000 төгрөгийг хавсралтад заагдсаны дагуу зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 1.902.000 төгрөг /нэг сая есөн зуун хоёр мянга/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 4.12 дахь заалт “Иргэдийн эрх зүйн боловсрол олгох” дэд хөтөлбөрөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

